



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/109

Есөнбулаг сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 03 дугаартай хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Байгаль орчны газрын Ой, аж ахуйн хэлтсийн дарга М.Дашпунцаг нь 2026 оны 02 дугаар сарын 17-ны өдөр таалал төгссөнтэй холбогдуулан түүний ар гэрээс аймгийн Засаг даргад ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах 13,000,000 (арван гурван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

